

Үнэт зүйл, түүний гурвал

Б.Жадамба^{а*}, Б.Сүхболд^б

^аМонгол Улсын Боловсролын Их Сургууль, БоСС, Боловсролын суурь судалгааны төв,
^бМонгол Улсын Боловсролын Их Сургууль, Захиргаа

Хураангуй

Бид энэхүү өгүүлэлдээ Монголчуудын үнэт зүйлсийн талаар баримтын шинжилгээний арга ашиглан тодруулж, түүнийгээ Монголын уламжлалт соёлын нэгэн хэсэг болох амь ухаан, гурвал онол буюу нэгэн ертөнцийн хандлагын үүднээс авч үзэн судалж байна. Ингэж тодруулсны үндсэн дээр Монголчуудын нийтлэг үнэт зүйлс нь “эв эе”, “эрдэм”, “энэрэнгүй үзэл”, “тэгш байдал, шударга ёс”, “хүн чанар”, Хувь хүний оршихуйн үнэт зүйл нь хүн ёс, хууль ёс, боловсрол, ёс суртахуун тус тус байна гэж дүгнэж байна.

Түлхүүр үг

Үнэт зүйл, амь, ахуй ухамсрын түвшний гурвал; ёс, эрдэм, байгал, соёл, ид, эв /үйл/, орон /цаг/

Судалгааны дизайн

Бидний судалгааны шинжигдэхүүн нь үнэт зүйлсийн талаарх Монголын ба гадаадын эх сурвалжууд байна. Үнэт зүйлс гэж юу вэ? гэсэн шинжих зүйлээ баримт судлах аргазүйн дагуу шинжин бид нэгэн хүн, түүний үнэт зүйлсийн талаарх нэгэн төсөөллийг хэлэлцүүлж байна.

Нэгэн хүн, түүний үнэт зүйл

Бид ухагдахууны шинжилгээ хийхдээ баримт бичгүүд, судлаачдын бүтээлд ихээхэн тааралддаг хувь хүний үнэт зүйлсийг нэгэн үнэт зүйлс, нэгэн хүний үнэт зүйлс, суурь үнэт зүйлс гэсэн гурамсан холбоо бүхий ухагдахуунуудын гурвал бүтцэд нь авч үзлээ.

Нэгэн хүний үнэт зүйл нь “Үнэт зүйл* -Үйл* -Нэг*” гэсэн “амь-ахуй-ухамсар” (Нагаанбуу, 1999, х.21) лугаа гурвал бүтэц бүхий зүйл. Эл гурвал бүтцийг Амь, Ахуй, Ухамсрын Ухааны амь, ахуй, ухамсрын түвшинд дараах байдлаар ухаарч болох байна.

Хүснэгт 1


Нэгэн хүний үнэт зүйлийн гурвал

Чанарын тал / Түвшин	НЭГ /Ахуй/	ҮЙЛ /Амь/	Хүн /Ухамсар/
Амь /уг чанар буюу хорвоогийн шалтгаан/	Ёс	Үйл	Эрдэм
Ахуй /амьдрал хийгээд сэтгэлийн баримт/	Бие	Сэтгэл	Оюун
Ухамсар /хүн,амьтан ...ертөнц/	Мэдлэг	Эрүүл мэнд	Боловсрол

Нэгэн үнэт зүйл бол үнэт зүйлсийн ерөнхий бүтэц. Тэр нь /ахуй/ талдаа байгал, ёс, бэлгэ, үйл /ухамсар/ талдаа соёл, эрдэм, билиг, нэгэн /амь/ талдаа эв, үйл (сэдхэл/сэтгэл), Нэг (Ид) болно. Нэгэн хүн нь зөвхөн “Нэг” хүнийг бус, хүний орчинг нэгдэлд нь авч үзсэн ухагдахуун юм /зураг 1/.

Зураг 1

“Нэгэн хүн” тогтолцоот бүтэц



Уг загварт бид нэгэн хүнийг ёс, эрдэм, хүн, орчны хүрээнд авч үзсэн болно. Тэр нь ахуй түвшиндээ (орчин-байгаль)-(байгал-соёл)-(нийгэм-хүн) гэсэн гурвал бүтэц бүхий байна. Байгаль нь биднийг хүрээлэн буй орчин. Байгал нь нэгэн хүний байгалиас заяасан төрмөл чанар. Соёл нь хүний хувьд нийгмийн төрмөл чанар. Энд сонирхол татаж буй нэг зүйл нь “Ид/Үйл*” юм. Сэтгэл судлалын шинжлэх ухаан дахь З.Фрейдын онолоор “Ид, Эго, Супер Эго” гэсэн

* ✉ jadambaabadrakh@msue.edu.mn

гол ойлголтууд байдаг (Фрейд¹, 1938). Эго нь хувь хүнд зөвхөн өөрт нь орчин нөхцөлөөс шалтгаалан өгөгдсөн ойлголт-ухамсар, супер эго нь нийгмийн гишүүн хүн бүрд нэгэн утгатай ойлгогддог санаа, *ИД нь хүнд төрөлхийн заяагдсан инстинкт маягийн оюун санаа* (ухамсарлагдаагүй санаа бодол) болно. Монгол хэлэнд Ид чадал, Ид эрдэм дээрээ... гэх зэргийн хэлц үг байдаг. Эдгээрийг сайтар судлах хэрэгцээ, шаардлага бидэнд байна.

Суурь үнэт зүйлс нь сонгож болдоггүй бөгөөд Ахуйн түвшинд эх орон, эрүүл мэнд, эцэг эх /гэр бүл/, Амины түвшинд эв /үйл/-/Орон Цаг/, ёс, эрдэм, Ухамсрын түвшинд нэг, байгал, соёл юм. Амины түвшний зүйлс нь заяагдмал, төрмөл шинжтэй. Ёс, эрдмийн нэгдэл, Байгал, соёлын нэгдэл нь Ид юм.

Хүний оршихуйн тухай “Оршихуй хэмээгч нь хэрэг явдал бүхэнд, цөм ёс явдал бүхэнд, цөм ёс журамд яв цав нийлэлцэхүй” (Дэмчигдорж, 1913, х.54) гэдгээс нэгэн хүн оршин амьдрахуй гэдэг нь орчинтойгоо харилцан нөхцөлдөхүйн нэр байна.

Оршихуйн цөм нь Үйл, Явдал, Ажил, Хэргийн хоршил байна. Тэр үйл явц /процесс/ ба үйл ажиллагаа /механизм/ гэсэн талуудын нэгдэл юм.

Үйл явц бол оршихуйн процесс буюу харагдах тал. Үйл ажиллагаа бол түүний механизм буюу үйл ажиллагаа тал. Дандаа явц буюу өнгөц талыг нь харах биш, цаад ажиллагааны зүй тогтлыг ойлгох нь чухал байдаг.

Оршихуйн үнэт зүйлсийн Ахуй тал нь тэгш байдал, шударга ёс, эрх чөлөө, Ухамсар тал нь хүн чанар, мэдлэг, чадвар, Амь тал нь эв эе, эрдэм чанар, эв дүй байна.


Бид нэгэн судалгаагаар орон нутагт амьдарч байгаа хүмүүсээс “Танай нутагт амьдардаг эрдэмтэй хүн хэн бэ? Эрдэм гэж юуг ойлгож байна вэ?” гэсэн асуултад “Эв дүй”-тэй хүнийг хэлнэ гэсэн хариултын давтамжийн тоо хамгийн олон байв. Тухайлан нэрлэгдсэн хүмүүс дотор сургууль соёл төгсөөгүй, хүмүүсийн ярьдагчлан “Амьдралын хар ухаан”-тай хүн олон байсан нь сонирхолтой үр дүн байв. Энэ жишээнээс харахад бид сургуулиар хүүхдийг “Амьдрахгүй ухаан”-д бэлтгээд байгаа юм биш биз гэсэн асуулт, эргэлзээ гарч байна.

Нэгэн амьдрахуйг орон/цаг, нэг/үйл, мөнгө/эд, эрдэм/сэтгэл гэсэн хоршил талуудаас нь шинжсэн бөгөөд судлаач А.Цог-Очир нарын өгүүлэлд цаг, мөнгө хоёр бүх хоршлоороо таардаг тухай тэмдэглэсэн байдаг. Цаг үрэв, мөнгө үрэв

гэх мэт нь Цаг, Мөнгө хоёр бол нэг юмны хоёр тал гэсэн санааг агуулна. Үүнтэй адил мөнгө-эд; эд-мөнгө гээд хоршоо нийцлүүд байна. Энэ нь ахуй талын ухаан буюу хууль зүйд түшиглэсэн хөгжил буюу зах зээлийн ухаан юм.

Гэтэл Монголчуудын уламжлалт өвөг сэтгэхүйгээр аливаад Эрдэм, Сэтгэл, Үйл талаас нь хандах ба энэ нь хүн ёсонд суурилсан хөгжил байна (Жадамбаа, 2017, х.69). Эдээр биеэ чимэхээр, эрдмээр биеэ чим гэдэг зүйр үгийн утга санаа үүнийг илэрхийлнэ. Бид хүн ёс, хууль ёс хоёрыг зэрэгцүүлэн хөгжүүлж авч явах учиртай ч, өнөөдөр хууль ёсны зарчмыг хатуу баримтлан, хүн ёсоо түшсэн зарчмыг орхигдуулдаг байна.

Зураг 2
Нэгэн амьдрахуйн бүтэц



Амьдрахуйн үнэт зүйлсийн Ахуй тал нь цаг, эд, мөнгө, Ухамсар тал нь хүн ёс, боловсрол, ёс суртахуун, Амь тал нь амьдрал, ажил, арга болно. Өнөө үед бид боловсролын тухай ярихдаа ёс суртахуун, хүн ёсыг нь орхигдуулсаар байна. “Эрдмийн түлхүүр багш, Амьдралын түлхүүр ажил, Ажлын түлхүүр арга” гэсэн зүйр үг нь амьдрахуйн үнэт зүйлийн Амь-ны түвшинг бүрэн илэрхийлсэн утгатай юм. ХХI зуунд өөрөө ажлын байраа бий болгодог, үйлдвэрлэдэг, бүтээдэг, эрдэмтэй хүний хөгжил нь үнэт зүйл болно.

Дүгнэлт

Бид Үнэт зүйл, түүний гурвалын тухай Монголын болон гадны эх сурвалжуудыг шинжлэн судалсны үндсэн дээр дараах дүгнэлтийг хийж байна.

1. Бид үнэт зүйлсийн тухай авч үзэхдээ орчин буюу ахуйтай холбоотой талыг нь илүү

1 Freud

- анхаарч, хүнтэй холбоотой буюу амин талыг нь орхигдуулж ирсэн байна.
2. Цаашид үнэт зүйлсийн ахуйн тал, ухамсрын тал болон тэдгээрийг нэгсүүлэгч амины талыг анхааран үзэх нь зүйтэй юм.
 3. Үнэт зүйл, түүний гурвалыг хүснэгт 1, зураг 1, 2 -д томъёолсноор авч үзнэ.

Ашигласан материал

- Freud, S. (1938). *Basic writings of Sigmund Freud*. New York: Modern Library.
- Жадамбаа, Б. (2017). *Тэгш хөгжил, тэгш хагжлийн төлөөх боловсрол*. Улаанбаатар: Эдмон.
- Дэмчигдорж, Ч. (1913). *Эрдэнэт толь*. Улаанбаатар: Монголын хэвлэлийн үйлдвэр.
- Нагаанбуу, Н. (1997). Монгол гурвал онол: ертөнцийн гурвал. Улаанбаатар

Value, it's triple

B.Jadamba^a, B.Sukhbold^b

^aMongolian National University of Education, Fundamental Research Center of Education

^bMongolian National University of Education, Administration

Abstract

This study aims to identify 'Mongolian values', while using the different sources and document analysis. We have developed an imaginative description on "One person, his values" based on the categorized analysis on the national and international resources and books which explained descriptions and phenomena of "Value". We have developed an idea of 'one person' and 'his value' as we analyze the values of Mongolian and foreign sources and researchers' works. A person, his or her values of life and the consciousness level concerned with the level of consciousness of the body, mind, actions and intellect, which are related to life or actions, physical, emotional, intellectual levels. The fundamental values are not chosen and in practical level 'motherland', 'health' and 'parents' /family/, at the level of harmony, 'peace' /time/, 'ethics', 'knowledge', and in conscience level, it is 'nature' and 'culture'.

Key words

Value, it's triple, gene, livelihood, consciousness, wisdom, culture, ID, harmony, area /time/